

**ЭРХТЭН, ЭД, ЭС ШИЛЖҮҮЛЭН СУУЛГАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ БОЛОН
ХАМТ ӨРГӨН МЭДҮҮЛСЭН ХУУЛИЙН ТӨСЛҮҮДИЙН ЭЦСИЙН ХЭЛЭЛЦҮҮЛЭГТ
БЭЛТГЭСЭН ТАЛААРХ ХҮНИЙ ХӨГЖИЛ, НИЙГМИЙН БОДЛОГЫН
БАЙНГЫН ХОРООНЫ ТАНИЛЦУУЛГА**

2026 оны 04 дүгээр
сарын 28-ны өдөр

Улаанбаатар
хот

Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн Б.Баярбаатар

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлын гишүүн Ж.Чинбүрэн, Ж.Алдаржавхлан, А.Ариунзаяа, Н.Батсүмбэрэл нараас 2025 оны 03 дугаар сарын 31-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг Улсын Их Хурал 2026 оны 04 дүгээр сарын 23-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаараа хэлэлцэж, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороонд шилжүүлсэн билээ.

Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороо 2026 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн хуралдаанаараа хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлд заасны дагуу явуулсан бөгөөд эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа амьгүй донорын гэр бүлд олгох оршуулгын тэтгэмжийг тодорхой мөнгөн дүнгээр болон хүн амын амьжиргааны доод түвшинтэй уялдуулах боломжийн талаар, Улсын Их Хурлын гишүүн Л.Энхнасан амьгүй донорын гэр бүлд олгох оршуулгын тэтгэмжийг Эрүүл мэндийг дэмжих сангаас гаргах нь хуульд нийцсэн эсэх, Улсын Их Хурлын гишүүн Б.Бейсен тээгч эхээр хүүхдээ төрүүлэх зохицуулалтын талаар тус тус асуулт асууж, хариулт авлаа.

Улсын Их Хурлын 2026 оны 04 дүгээр сарын 23-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед хуралдаан даргалагчаас өгсөн гүйцээн боловсруулах чиглэлийн дагуу Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1 дэх заалтыг баримтлан зарчмын зөрүүтэй 4 саналаар санал хураалт явуулахад хуралдаанд оролцсон гишүүдийн олонх нь дэмжсэн болно.

Нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан саналыг хуулийн төслүүдийн холбогдох зүйл, хэсэг, заалтад нэмж тусган хэл найруулга, дэс дараалал, зүйл, заалтын дугаарыг нийцүүлэн өөрчилж, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн хуулийн төслийг Та бүхэнд тараасан болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Иргэний улсын бүртгэлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Донорын тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явуулсан талаарх Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны танилцуулга, зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

ХҮНИЙ ХӨГЖИЛ, НИЙГМИЙН
БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА



П.ГАНЗОРИГ

**ЭРХТЭН, ЭД, ЭС ШИЛЖҮҮЛЭН СУУЛГАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН
ТАЛААРХ ЗАРЧМЫН ЗӨРҮҮТЭЙ САНАЛЫН ТОМЬЁОЛОЛ**

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар
зүйлийн 42.2.1 дэх заалтыг үндэслэн хураалгасан санал:

1.Төслийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсгийн “Эрхтэн, эд” гэсний дараа “, эс” гэж, мөн зүйлийн 6.2.1 дэх заалтын “гэрлэлтээ бүртгүүлснээс хойш 3-аас доошгүй жил” гэсний дараа “, бэлгийн эс шилжүүлэн суулгах тохиолдолд нэгээс доошгүй жил” гэж мөн заалтын “гэрлэгчид дундаасаа” гэсний дараа “төрсөн” гэж, мөн зүйлийн 6.2.2 дахь заалтын “гадаад улсын иргэн,” гэсний дараа “харьяалалгүй хүн” гэж, мөн заалтын “эрхтэн, эд” гэсний дараа “,эс” гэж тус тус нэмж, мөн зүйлийн 6.2.1 дэх заалтын “тус улсад” гэснийг хасах.

Санал гаргасан: Хүний хөгжил, нийгмийн
бодлогын байнгын хороо

2.Төслийн 15 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 15.13, 15.14 дэх хэсэг нэмэх:

“15.13.Нэг донорын бэлгийн эсийг зөвхөн тухайн нэг гэр бүлд ашиглахыг зөвшөөрнө.

15.14.Үр хөврөлийг эцэг, эхээс нь бусад хүмүүст ашиглахыг хориглоно.”

Санал гаргасан: Хүний хөгжил, нийгмийн
бодлогын байнгын хороо

3.Төслийн 22, 23 дугаар зүйлийг нэгтгэн 22 дугаар зүйл болгож, доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“22 дугаар зүйл. Амьгүй донорын гэр бүлд олгох тэтгэмж болон амьд донорт үзүүлэх дэмжлэг

22.1.Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 10 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний оршуулгын тэтгэмжийг эрүүл мэндийг дэмжих сангаас олгоно.

22.2.Амьд донорт эмнэлгийн тусламж, үйлчилгээг хөнгөлөлттэй үзүүлэх журмыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, рашаан сувилалд сувилуулах журмыг гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.”

22.3.Хуульд заасан бусад.”

Санал гаргасан: Хүний хөгжил, нийгмийн
бодлогын байнгын хороо

4.Зарчмын зөрүүтэй 3 дугаар санал буюу хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 10 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний оршуулгын тэтгэмжийг эрүүл мэндийг дэмжих сангаас олгох санал дэмжигдсэнтэй холбогдуулан хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл болон Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулах.

Санал гаргасан: Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороо

---oOo---